



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны "Албан бус сургалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.


ХУРАЛ ДАРГАЛАГЧ



П.ОДГЭРЭЛ



АЛБАН БУС СУРГАЛТЫН ЖУРАМ



АЛБАН БУС СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл:

1.1 Энэ журмаар Монголын Хуульчдын холбоо /цаашид "Холбоо" гэх/-оос эрх зүйн албан бус сургалт зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Албан бус сургалтын зорилго нь нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай суурь мэдлэг, чадварыг олгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хуульчдын үүрэг оролцоог дээшлүүлэх, хандлагыг төлөвшүүлэх, хууль сурталчлах үйл ажиллагаанаас олсон орлогоор Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

2 дугаар зүйл. Нэр томъёоны тайлбар:

Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1 "Албан бус сургалт" гэж энэхүү журмын 1.2 дугаар зүйлд заасан зорилгод нийцсэн, Холбооны сургалтын хороогоор зөвшөөрөгдсөн, Холбоотой байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийг үндэслэн захиалгат, эсхүл Холбооны санаачилсан, санал болгосон, бие дааж, эсхүл бусадтай хамтарч төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр зохион байгуулах сургалтыг ойлгоно.

3 дугаар зүйл. Албан бус сургалтын асуудлаар Холбооны зөвлөлийн бүрэн эрх

3.1. Холбооны Зөвлөл албан бус сургалттай холбоотой асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Албан бус сургалтын талаар Холбооноос баримтлах бодлогыг тодорхойлж, сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;

3.1.2 Албан бус сургалтын талаар Тамгын газар, Сургалтын хорооны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

3.1.3 Тамгын газраас гаргасан тухайн жилд албан бус сургалт явуулах төлөвлөгөөтэй танилцах;

ХОЁР ДУГААР БҮЛЭГ

АЛБАН БУС СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

4 дугаар зүйл. Албан бус сургалт зохион байгуулах

4.1 Албан бус сургалтыг зохион байгуулах ажлыг Тамгын газар, Сургалтын хороо хэрэгжүүлнэ. Сургалтад бусад чиг үүргийн болон сайн дурын хороодыг татан оролцуулна.

4.2 Тамгын газар албан бус сургалтын захиалга авах, сургалт явуулах журам болон сургалтын төлбөрийн багц үнийн саналыг сургалт авах хүсэлтэй байгууллага, хуулийн этгээдэд хүргүүлэн танилцуулж зохион байгуулалтыг хариуцна.

4.3 Тамгын газар улиралд нэг удаа албан бус сургалтын төлбөртэй холбоотой санхүүгийн тайланг гаргаж Холбооны Ерөнхийлөгчид танилцуулна.

4.4 Сургалтын хороо нь тухайн албан бус сургалт нь хөтөлбөртэй байх шаардлагатай гэж үзвэл хөтөлбөрийг хэлэлцэж, сургалт явуулах зөвшөөрөл олгоно.

4.5 Албан бус сургалтын нэгдсэн төлөвлөгөөг тухайн жилд шинээр батлагдсан болон батлагдахаар төлөвлөгдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн агуулга, мэдээллийн хэрэгцээ, шаардлага, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн саналд тулгуурлан Сургалтын хороо жил бүр шинэчлэн батална.

4.6 Сургалтын хороо нь жил тутам Албан бус сургалтын үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргах, мэдээлэх, тайланд хяналт-шинжилгээ хийж холбооны зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

4.7 Тамгын газар нь сургалтын захиалгад үндэслэн Салбар эрх зүйн хороо, хувь хуульч, хуулийн байгууллагын сургалт, судалгааны нэгж, өмгөөллийн нөхөрлөл, компанитай хамтарч зохион байгуулж болно.

5 дугаар зүйл. Албан бус сургалтын санхүүжилт, төлбөр

5.1 Албан бус сургалт төлбөртэй байж болох ба төлбөрийн хэмжээг захиалагч байгууллагатай харилцан тогтооно.

5.2 Албан бус сургалтын төлбөрөөс 60 хүртэл хувийг хичээл заасан багшид олгоно.

5.3 Хуульчийн нийтэд тустай ажил болон иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд хууль таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион явуулах сургалт үнэ төлбөргүй байна.

6 дугаар зүйл. Албан бус сургалтад хичээл заах сургагч багш, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага.

6.1 Албан бус сургалтын хичээлийг заах сургагч багш нь сургалтын сэдвийн хүрээнд мэдлэг чадвартай байх.

6.2 Албан бус сургалтын хөтөлбөр нь захиалагчийн шаардлагад нийцсэн, хэрэгцээг хангахад чиглэгдсэн байх бөгөөд Сургалтын хорооноос баталсан сургалтын хөтөлбөр, ерөнхий чиглэлийн хүрээнд боловсруулагдсан байна.

6.3. Албан бус сургалтын хичээл заах сургагч багшийг чиг үүргийн болон сайн дурын хороодоос ирүүлсэн саналд үндэслэн сонгох ажлыг Сургалтын хороо зохион байгуулна.

6.4. Сургагч багш онолын мэдлэг, заах арга зүй, ур чадвараа байнга дээшлүүлэх үүрэгтэй.

7 дугаар зүйл. Албан бус сургалт явуулах хэлбэр

7.1 Албан бус сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр явуулж болно.